

**Петро Матад Лимитед (“Петро Матад” эсвэл “Компани” гэх)  
Давсан Толгой-1 Хайгуулын Цооногийн Талаарх Шинэ Мэдээлэл**

Петро Матад компанийн Давсан Толгой-1 (DT-1) хайгуулын цооногийн гүн нь 2010 оны 7 дугаар сарын 14-ны байдлаар 1,220 м-ийн хэмжилтийн гүнд хүрээд байна. Тус цооног нь 1,075м-1,146м гүнд байрлах Цагаанцавын Формац гэж нэрлэгддэг тогтоцыг дайран өнгөрч метаморфик суурь чулуулагт орсон. Нийт 71 метр Цагаанцавын тогтоц нь ойролцоогоор нийт 35м зузаан зургаан элсэн чулуу ба уулын чулуулагийн хэсгүүд дэхь газрын тосны илэрц бүхий газрын тос ба гадарга дээрх шаврын хийг агуулдаг. Хэд хэдэн ийм завсруудад газрын тосны хэсэг, флоресенс, газрын тосны толбо ба газрын тосны үүхтэй үнэр гарах зэрэг нэлээд сайн шинжүүд илрдэг. Элсэн чулуу ба уулын чулуулагийн хэсгээр хурдан өрөмдөгдөж байвал нөөцийн чанар сайн байна гэж үзнэ.

Доод Цагаанцавын тогтоц нь 3 хэмжээст чичирхийллийн прогнозын урьдчилсан дүнгээс ойролцоогоор 150м өндөр байгаа нь үүний урьдчилан тооцоолсон зузаанаас 2 дахин бага байгаа юм. Тус Компани нь 2010 оны 7 дугаар сарын 13-ны ажиллагааны шинэчилсэн мэдээлэлдээ газрын тосны дээд хэсгийн илэрц доод Зүүнбаянгийн давхарга аас илэрсэн хэмээн анхлан мэдээллэсэн боловч эдгээр завсрууд нь Цагаанцавын тогтоцон онцлог болох галт уулын элсэн чулуу болон элсэн чулуулагаас үүдэж байгааг тогтоосон байна. Цооногийн жинхэнэ ажиглалтуудыг ашиглан 3 хэмжээст чичирхийллийн прогнозийг дахин дамжуулсан. Энэ нь өрмийн цооногоос зүүн тийш байрлах тасралтгүй зузаарч байгаа доод Цагаанцавын элсэн чулуу бүхий дөрвөн талаараа хашлагатай нутгийн уулын давхаргыг өрөмдсөн болохыг баталж байна.

DT-1 цооногт каротажын судалгаа хийх бөгөөд энэхүү ажиллагааг дууссаны дараа DT-2 цооног руу өрөмдлөгийг шилжүүлнэ.

Удирдах зөвлөлийн шийдвэр ба өвшөөрлийн дагуу бие даасан давхаргын хаалт дотор, Тамсагийн сав газрын үржил шимтэй бүстэй зэрэгцэн оршдог DT -1 цооногоос баруун тийш 4 км зайд байрлах доод Цагаанцавын DT-2 цооногт 2000 м-ийн гүнд туршилт явуулах юм.

Компани нь тухай бүр цаашдын мэдээллүүдийг хийж байх болно.

Тус Компаний үйлцэтгэх Захирал Дуглас МкГэй хэлэхдээ “Нэгдүгээр цооногийн ажиллагааг амжилттай хэрэгжүүлэх нь Монгол улс болон манай компанийн хувьд томоохон ололт амжилт бөгөөд энэ нь манай техникийн багийнханы ач тус юм. Хэдийгээр нээн илрүүлэх шинжлэх ухааны туршилт ба анализуудыг дөнгөж эхлүүлээд байгаа боловч DT-1 цооногт Давсан Толгой Фсөл бол бидний анх таамаглаж байсан члан хэрэгжүүлэх боломжтой төлөвлөгөө болохыг батлах хангалттай ажлыг хийгээд байна. Бид эвхэн их хэмжээний нүүрстөрөгчийг илрүүлээд зогсохгүй, шинжлэх ухааны мэдлэгээ дээшлүүлж байгаа нь цооногуудтай холбоотой цаашдын эрсдлүүдийг багасгаж байгаа юм.”

Түүнчлэн энэ нь Матад ХХ дахь хэтийн төлөв болон бусад гол чиглэлүүдэд итгэл үнэмшил нэмж, Матад ХХ дахь бусад 6 жижиг сав газруудад о д о ч хайгуул хийн, туршилт хийсээр байна.

Бид Матад ХХ-ын ирээдүйд итгэлтэй байна”.

Энэхүү мэдээний техникийн мэдээллийг тус Компаний Хайгуулын Менежер доктор Жэймс Күүган хянаж үзсэн болно. Доктор Күүган Хойд Америк болон олон улсын хайгуул, боловсруулалтын ажлын 29 жилийн туршлагатай газрын тосны геологийн Тэрээр Америкын Газрын Тосны Геологичдын Холбоо болон Америкын Геологийн Нийгэмлэгийн гишүүн.

### **Редакторуудад зориулсан санамж:**

#### **Петро Матадын тухай**

Петро Матад нь газрын тосны хайгуул болон цаашдын олборлолт, үйлдвэрлэлийг Монгол улсад эрхлэх чиглэлээр ажиллаж байгаа группын толгой компани юм. Тус групп нь Монгол улсын засгийн газартай байгуулсан гурвантэй бүтээгдэхүүн Хуваах Гэрээнүүдийг дангаараа гүйцэтгэгч байгууллага болно. Гол хөрөнгө нь тус орны алс дорнодод байрлах 14,250 квадрат км талбай бүхий газрын тосны ХХ блокод байгуулсан Бүтээгдэхүүн Хуваах Гэрээт талбай. Нөгөө хоёр 4 ба 5-р блокууд нь Монгол улсын өв хэсэгт байрлах бөгөөд хамтдаа 73,498 квадрат км талбайтай.

Петро Матад Лимитед компани нь Айс оф Мэн ард 1438-р дугаартай б байгуулагдсан компани бөгөөд албан ёсны бүртгэлтэй төв байр нь Виктори Байшин, Проспет Хилл, Дуглас, Айс оф Мэн, Ай Эм 1 – ИКю хаягт байрладаг болно.

### **Цаашдын мэдээллийг дараах хаягаар авч болно:**

Петро Матад Лимитед Дуглас Жэй. МкГэй- Гүйцэтгэх Захирал	+976-11-331099
Вестхаус Секюритис Лимитед Ричард Бэйти / Петре Нортон	+44/0/ 20 7601 6100
Банкны талын зөвлөхүүд Саймон Розсчайлд / Оливер Винтерс / Луйс Мэйсон	+44/0/ 20 7367 8888